

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
аудитын тайлан

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аймаг, сумдын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын бүтэц, орон тоонд багтан үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх байдал алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Сүхбаатар сум
2018 оны 11 сар

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:

Ч.Энхтуяа

Аудитын менежер:

Б.Батмөнх

Ахлах аудитор:

С.Бат-Эрдэнэ
С.Баасансүрэн
Ц.Отгонбаяр

Аудитор:

А.Дашбат
Ж.Цогт

Аудитын
тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
7036-3040, 7036-3036,
7036-2442 дугаарын
утас,
Selenge.audit.gov.mn
email хаягаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2018 оны 9-11 сар

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл

А.Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна уу?

*А.1 Төрийн сангийн эрх зүйн орчин, тогтолцоо зөв
оновчтой эсэх ?*

*А.1.1 Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд
оновчтой тодорхойлсон уу?*

*А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй
хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна
уу?*

*А.2 Төрийн сангийн тогтолцоо бодлого, чиг
үүрэгтэйгээ нийцэж байна уу?*

*А.2.1 Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх
зүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна
уу ?*

*А.2.2 Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах
зайлшгүй бодит хэрэгцээ шаардлага байна уу ?*

*А.3 Төрийн сан хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн
зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий
болгосон уу ?*

*А.3.1 Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын
байрны тодорхойлолттой нийцэж байна уу ?*

*А.3.2 Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар,
хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаж байна уу?*

*А.4 Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах
бодлого стратеги байна уу?*

*А.4.1 Сангийн яамны дунд хугацааны стратегийн
төлөвлөгөөндөө Төрийн сангийн үйл ажиллагааг үр
нөлөөтэй явуулах бодлого тусгасан байна уу?*

*А.4.2 Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй
явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын
төлөвлөгөө, биелэлтийг үнэлж чадаж байна уу?*

Б.Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна уу?

*Б.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв,
мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль
тогтоомжийн дагуу үр нөлөөтэй гүйцэтгэж байна уу?*

*Б.1.1 Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу
аюулгүй, үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэж байна уу?*

*Б.1.2 Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн
хөрөнгийн удирдлага үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?*

*Б.1.3 Төсвийн хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулж
байна уу?*

Б.2 ЗГСУМС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?

Б.2.1 Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан уу?

Б.2.2 Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан уу?

Б.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Б.3.1 Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Б.3.2 Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал, шийдвэрлэлт

Хавсралт судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОУВС	Олон улсын валютын сан
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
ЭМГ	Эрүүл мэндийн газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

I. Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 оны төлөвлөгөө болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

II. Аудитын зорилт

Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж, дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ: Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх ?
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх?

III. Аудитын хамарсан хүрээ

Аудитыг төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд аймаг, сумдын төрийн сангийн нэгж, зарим төрийн байгууллагуудыг хамруулав.

IV. Аудитын арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан Гүйцэтгэлийн аудитын журам, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх , санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх , үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтот арга хэмжээнээс түүвэрлэн горим, сорил хэрэгжүүлэв.

Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

V. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав: Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль ,
- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль ,
- Шилэн дансны тухай хууль ,

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд,

Засгийн Газрын тогтоол:

- Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай 2017 оны 116 дугаар тогтоол
- Санхүүгийн алба байгуулах тухай 2014 оны 326 дугаар тогтоол
- 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”,

Сангийн сайдын тушаал:

- 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”
- 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур “
- 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”
- 2013 оны 24/ А-9 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банканд нээх, хаах журам”
- 2014 оны 45 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам”
- 2014 оны 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”
- 2014 оны 95 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам” /2015 оны 129 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон/
- 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “ Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”,
- 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “*Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам*” ,
- 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” болон бусад холбогдох журмууд.

VI. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, С.Баасансүрэн, Ц.Отгонбаяр, аудитор А.Дашбат, Ж.Цогт нар хийж гүйцэтгэв.

VII. Аудитын хугацаа

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 8 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 14-ний хооронд, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцэслэсэн тайланг ҮАГ болон бусад холбогдох байгууллага албан тушаалтнуудад 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан хүргүүлнэ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд Засгийн газрын дараах тогтоолуудаар шилжсэн байна. Үүнд:

- 2001 оны 125 дугаар тогтоолоор “ Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал”-ын 2.1.3-т төсвийн санхүүжилтийн гүйлгээг зохицуулах, бүртгэл хийх, тайлан гаргах үүрэг бүхий Төрийн сангийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, шилжүүлэх үйл явцыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан байна.
- Засгийн газрын “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай “2002 оны 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлсэн байна.
- Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолоор Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд агентлагууд, Засгийн газрын тусгай зориулалтын сангууд болон өөрийн орлоготой байгууллагууд, Нийгмийн даатгалын сангуудыг хамруулсан. Мөн төрийн сангийн харилцах дансыг Монгол банк дахь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах асуудлыг ОУВС-тай зөвшилцөн шийдвэрлэх гэсний дагуу арилжааны банканд байршиж байсан төсөвт байгууллагуудын харилцах дансны үлдэгдлийг төрийн сангийн бүртгэлийн дансанд шилжүүлэн байршуулж, төрийн сангаас төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4, 36, 37 дугаар зүйлд Төрийн сангийн тогтолцоо, нийтлэг чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд аймгийн болон 17 сум, 5 тосгоны төрийн сангийн нэгжид нийт 48 ажилтан ажиллаж, төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Аймгийн ЗДТГ-ын СТСХ –нь хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн зарлагын мэргэжилтэн, орлого бүртгэлийн мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тус бүр 1, төлбөр, тооцооны мэргэжилтэн 2 зэрэг нийт 7 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бол сум, тосгоны төрийн сангийн нэгжид 17 санхүүгийн албаны дарга, 2 төрийн сангийн төлөөлөгч, 22 төсөв, төрийн сангийн мэргэжилтэн ажиллаж байна.

Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнээр зардлыг зүйл ангиар бүлэглэн зарцуулах зарцуулалтад тавих хяналт сайжирч , мөнгөн хөрөнгийг үр дүнтэй удирдах боломжтой болсон байна.

Бүлэг А

А.Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна уу?

Аймаг, сумдын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын дэргэд бус ЗДТГ-ын бүтцэд багтан үйл ажиллагаа явуулж байна.

А.1 Төрийн сангийн эрх зүйн орчин, тогтолцоо зөв оновчтой эсэх

Аймаг, сумдын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын бүтэц, орон тоонд багтан үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх байдал алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

А.1.1 Төрийн сангийн чиг үүргийг холбогдох хуульд оновчтой тодорхойлсон уу ?

Төрийн сангийн чиг үүргийг Төсвийн тухай хуульд оновчтой тодорхойлсон байна.

А.1.1.1 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “Төрийн сангийн үйл ажиллагаа гэж” төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

А.1.1.2 Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна: Үүнд:

- Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;
- Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх,
- Төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх:
- Төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох
- Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж, хяналт тавих
- Төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх
- Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах
- Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох

Ингэснээр Төсвийн тухай хуульд төрийн сангийн чиг үүргийг оновчтой тодорхойлсон байна гэж үзэж байна.

А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна уу?

Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актууд бусад хууль, тогтоомжуудтай зөрчилдөхгүй байна.

А.1.2.1 Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”, 2015 оны 431 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг” зэрэг хууль, тогтоомж, журмын хүрээнд зохицуулагдаж байна.

А.1.2.2 Аудитын явцад төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад хууль эрхийн акттай зөрчилдөж буй байдал ажиглагдаагүй бөгөөд харин Сангийн сайдын 2014 оны 07 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар шинэчлэн батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын зарим үзүүлэлт нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар”-тай зөрүүтэй байна.

А.2 Төрийн сангийн тогтолцоо бодлого чиг үүрэгтэйгээ нийцэж байна уу?

Аймаг, сумдын төрийн санг тухайн шатны ЗДТГ-ын бүтцэд багтаан зохион байгуулсан нь хараат бус байдал алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

А.2.1 Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага байна уу?

Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа зарим хууль, журам, зааварт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.2.1.1 Төсвийн тухай хуулийн 36.1-д “Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ”, 36.2 “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд байна” гэж заасан байдаг.



А.2.1.2 Гэтэл аймаг, сумдын төрийн сангийн нэгжийг тухайн шатны ЗДТГ-ын дэргэд бус бүтэц орон тоонд нь багтааж зохион байгуулсан нь Төсвийн тухай хуульд заасан тогтолцоо бүрэн хэрэгжихгүй, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэх нөхцөл боломжгүй байдалд хүргэж байна.

А.2.1.3 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан төрийн сангийн тогтолцоонд аймаг, нийслэл, сум, дүүрэг гэсэн засаг захиргааны нэгжүүдэд төрийн сан байхаар хуульчилсан боловч Сэлэнгэ аймгийн хувьд сумдаасаа алслагдсан Бугант, Дулаанхан тосгодод тус бүр төрийн сангийн төлөөлөгч, төрийн сангийн мэргэжилтэн гэсэн 2 хүн ажиллаж байгаа бол сумдтайгаа ойр байрладаг Түнхэл, Хэрх, Номгон, Рашаант зэрэг 4 тосгонд төрийн сангийн мэргэжилтэн ажиллаж байгаа нь хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна.

А.2.1.4 Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж байгаа зарим хууль, журам, зааврыг шинэчлэх, сайжруулах дараах асуудлууд байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн “Төрийн сангийн тогтолцоо” гэсэн 36 дугаар зүйлд тосгоны төрийн сангийн талаар нэмж тусгах,

- “Санхүүгийн алба байгуулах тухай”- ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолд тосгонтой сумдын Санхүүгийн албаны бүтэц, орон тоо, зохион байгуулалтын талаар нэмэлт өөрчлөлт хийж, тусгай заалт оруулж өгөх,
- Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар баталсан “ЗГСУМС-д мөрдөх журам”-д тосгоны төрийн сангийн төлөөлөгч, төрийн сангийн мэргэжилтний системд нэвтрэх ажил, үүргийн ангиллыг тодорхой тусгаж өгөх;
- Сангийн сайдын 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар”-ыг шинэчлэх,

A.2.1.5 Аудитын явцад төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх, үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжууд нь бүрэн хэрэгжиж байгаа эсэх, өөр хоорондоо зөрчилдөж байгаа эсэх талаар төрийн сангийн ажилтан 46 хүнээс санал асуулга авахад 84,1 хувь нь эерэг санал буюу төрийн сангийн тогтолцоо оновчтой байна, хууль тогтоомжууд өөр хоорондоо зөрчилдөхгүй, бүрэн хэрэгжиж байна гэж хариулсан байна.

A.2.1.6 Харин тайлангийн төсөлд санал авахад аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 13.1, 13.2-д “ улс, орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтын гүйлгээг тухайн сарын сүүлчийн ажлын өдөр банк хоорондын орлогын гүйлгээ импортлож дууссанаас хойш 1 цагийн дотор сум, дүүрэг, 2 цагийн дотор аймаг, нийслэлийн төрийн сан хийж гүйцэтгэнэ” гэж заасан нь бодит байдалд нийцдэггүй, төсвийн санхүүжилтүүдийг тогтмол хийх шаардлага гардаг учир орлогын дансны хаалтыг сард 1 удаа хийх боломжгүй, шаардлагатай тохиолдол бүр хийдэг гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

A.2.2 Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах зайлшгүй бодит хэрэгцээ шаардлага байна уу?

Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, төлөвлөх, тайлагнах чиг үүргийг төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжүүлэх чиг үүрэгтэй хамтатган гүйцэтгэж байна.

A.2.2.1 Төрийн сангийн нийтлэг 8 чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд тодорхойлж өгсөн бол нарийвчилсан чиг үүргийг “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-д тус тус зааж өгсөн байдаг.

A.2.2.2 Аудитын явцад төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлагатай эсэх талаар аймаг, сумдын төрийн сангийн ажилтан, сумдын Санхүүгийн албаны дарга 46 хүнээс асуулга авахад 69,6 хувь нь төрийн сангийн чиг үүргийг шинэчлэх шаардлагагүй гэсэн хариулт өгсөн байна. Өөрөөр хэлбэл төрийн сангийн ажилтнуудын олонх нь одоогийн гүйцэтгэж буй чиг үүрэгт сэтгэл хангалуун, шинэчлэн сайжруулах шаардлагагүй гэж үзэж байна.

A.2.2.3 Харин бидний гүйцэтгэсэн аудитын дүнгээс харахад төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, бүртгэх тайлагнах, санхүүжүүлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг аймагт ЗДТГ-ын СТСХ, сумдад Санхүүгийн алба хамтатган хэрэгжүүлж байгаа нь төсвийн захирагчийн холбогдох хууль тогтоомж зөрчин төлөвлөж, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг санхүүжүүлэх, төсвийн зарлагын дарааллыг журмын дагуу тогтоох, бүлэглэсэн дүнгээр хяналт тавих үндсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй байна. Иймээс төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, тайлагнах чиг үүргийг төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжүүлэх чиг үүргээс салгаж, зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

А.3 Хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтцийг бий болгосон уу?

Сумдын санхүүгийн алба нь хариуцаж байгаа байгууллагын тоо, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтаас шалтгаалан бүтцийн хувьд харилцан адилгүй зохион байгуулагдсан байна.

А.3.1 Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна уу?

Төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг нь ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна.

А.3.1.1 Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд хуульчилж өгсөн бөгөөд Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”-ыг баталсан байна. Дээрх заавар журмыг үндэслэн аймаг, сумдын төрийн сангийн нэгжийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг тухайн шатны ЗДТГ-ын дарга шинэчлэн баталгаажуулсан байна.

А.3.1.2 Аудитын явцад төрийн сангийн ажилтнуудын чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж буй эсэх талаар төрийн сангийн ажилтан 46 хүнээс асуулга авахад 69,6 хувь нь хэрэгжүүлж буй чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна гэж хариулсан байна.

А.3.1.3 Аудитын явцад хийсэн асуулга, тулган баталгаажуулалтаас харахад аймаг болон ихэнх сумдын төрийн сангийн ажилтнуудын хэрэгжүүлж буй чиг үүрэг нь ажлын байрны тодорхойлолттой нийцэж байсан бөгөөд харин Сайхан сумын Санхүүгийн албаны дарга нь сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн өдөр тутмын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж бүртгэл, тайлагналыг гүйцэтгэж байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”-ын 2.3.3¹ –д заасантай зөрчилдөж, төлбөр тооцоонд тавих хяналт сулрах эрсдэлийг үүсгэж байна.

А.3.2 Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаж байна уу?

Сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг нэн даруй өөрчлөн, нягтлан бодогчийн ажлын ачаалал, цалин хөлсний ялгавартай байдлыг арилгах шаардлагатай байна.

А.3.2.1 Ажлын чиг үүргийн давхардлын талаар аудитын явцад аймаг, сумдын төрийн сангийн ажилтан, сумдын Санхүүгийн албаны дарга зэрэг 46 хүнээс асуулга авахад 93,5 хувь нь төрийн сангийн хэрэгжүүлж буй чиг үүрэг бусад газар хэлтэстэй давхцахгүй байна гэсэн хариулт өгсөн байна.

А.3.2.2 Бидний хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээс харахад хэдийгээр төрийн сангийн хэрэгжүүлж буй чиг үүрэг нь бусад хэлтэс, албатай давхцахгүй байгаа боловч сумдын Санхүүгийн албаны бүтэц зохион байгуулалт, нягтлан бодогч нарын ажлын ачаалал,

¹ Нягтлан бодогч нь Засаг даргын нөөц хөрөнгө, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах сан, мал хамгаалах сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн өдөр тутмын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурах, бүртгэл хөтлөх, тайлагналыг хариуцах.

цалин хөлстэй холбоотой зайлшгүй авч үзэх шаардлагатай асуудлууд ажиглагдаж байна.

А.3.2.3 Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хийх, төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх Санхүүгийн албыг сумын ЗДТГ-ын бүрэлдэхүүнд байгуулахыг шийдвэрлэсэн байна.

А.3.2.4 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, Сангийн сайдын 2015 оны 326, 425, 426 дугаар тушаалуудыг үндэслэн Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/1086 дугаар албан бичгээр Санхүүгийн алба байгуулах чиглэлийг сумдад хүргүүлсэн байна. Мөн 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Сумын Засаг даргын Тамгын газар, тосгоны Захирагчийн албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан” А/475 дугаар захирамжаар Санхүүгийн албаны орон тоог сумын ЗДТГ-ын бүтцэд багтаан баталсан байна.

А.3.2.5 Дээрх хууль эрх зүйн актуудын хүрээнд 2016 оноос 14 сум Санхүүгийн албаны зохион байгуулалтад бүрэн шилжиж албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, төсөвт байгууллагууд хариуцсан нягтлан бодогч нар нь ЗДТГ-т харьяалагдсан бол Мандал, Сайхан, Сүхбаатар зэрэг төсөвт байгууллагын тоо олонтой 3 суманд Санхүүгийн алба байгуулалгүйгээр төрийн сангийн төлөөлөгч, төрийн сангийн мэргэжилтэн, сумын ЗДТГ-ын нягтлан бодогч 3 нь ЗДТГ-т харьяалагдаж байгууллага хариуцсан нягтлан бодогчид нь тус тусын байгууллагад харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна.

А.3.2.6 Санхүүгийн алба байгуулах тухай Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолд тосгоны талаар тодорхой зааж өгөөгүйгээс тосгодод Санхүүгийн албаны зохион байгуулалт хийгдээгүй байна. Дулаанхаан тосгоны төрийн сангийн мэргэжилтэн нь захирагчийн албаны, Бугант тосгоны төрийн сангийн төлөөлөгч нь захирагчийн албаны, төрийн сангийн мэргэжилтэн нь сургууль, соёлын төвийн нягтлан бодогчийн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцоонд тавих төрийн сангийн хяналтыг алдагдуулах эрсдэлтэй байна.

А.3.2.7 Санхүүгийн алба зохион байгуулагдсан 14 суманд нэг нягтлан бодогч дунджаар 3-5 байгууллага хариуцаж, 1 орон тооны цалин авч байгаа бол зохион байгуулагдаагүй 3 сум болон тосгоны төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нар 1-2 байгууллагыг хариуцан, үндсэн байгууллагаас авч буй цалин хөлсөн дээр хавсран ажилласны 30-40 хувийн нэмэгдэл цалин авч байна. /дэлгэрэнгүйг хавсралт №4- д үзүүлэв /

А.3.2.8 Эндээс үзэхэд сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалт нь сум, тосгодод харилцан адилгүйгээс 1 нягтлан бодогчид ногдож буй байгууллагын тоо болон цалин хөлс, нэмэгдэл нь эрс ялгавартай байдлыг үүсгэж, цөөн байгууллага хариуцсан нягтлан бодогч их цалин авдаг, олон байгууллага хариуцсан нягтлан бодогч бага цалин авдаг тогтолцоотой болж, ижил хөдөлмөрт ижил цалин хөлс олгох зарчим алдагдсан байна. Иймээс сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг нэн даруй өөрчлөн, нягтлан бодогчийн ажлын ачаалал, цалин хөлсний ялгавартай байдлыг арилгах нь зүйтэй юм.

А.4 Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого стратеги байна уу?

А.4.1 Сангийн яамны дунд хугацааны стратегийн төлөвлөгөөндөө Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлого тусгасан байна уу?

А.4.2 Төрийн сангийн үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, биелэлтийг үнэлж чадаж байна уу?

А.4 дэх дэд асуудал нь орон нутгийн түвшинд хамааралгүй гэж үзэн аудитын дэд төлөвлөгөөнд хасаж тусгасан болно.

Бүлэг Б

Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна уу?

Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журмуудыг бүрэн хэрэгжүүлж, төсвийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Б.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй гүйцэтгэж байна уу?

Төрийн сангийн нэгжүүд нь төсвийн байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.1.1 Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэж байна уу?

Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд төлбөр тооцоог гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүй байна.

Б.1.1.1 Сэлэнгэ аймгийн болон 17 сум, 5 тосгоны 23 төрийн сангийн нэгж нь аймаг, сумдын 18 төсвийн ерөнхийлөн захирагчийн болон улс, орон нутгийн төсвийн 220 төсвийн шууд захирагчийн **868** төрийн сангийн бүртгэлийн дансны төлбөр тооцоог гүйцэтгэж байна. 2017 онд нийт 70,994 ширхэг зарлагын гүйлгээгээр 154,589.6 мянган төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүдийн 2017 онд хийсэн гүйлгээг харьцуулсан судалгаа

Хүснэгт №1

№	Төрийн сангийн нэгжийн нэр	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний тоо	Бүртгэлийн дансны тоо	Нийт гүйлгээний тоо				Алдаатай / хасах / гүйлгээний		Орлого бууруулсан гүйлгээ	
				Тоо	Нийт дүнд эзлэх хувь	мөнгөн дүн (сая төгрөг)	Нийт дүнд эзлэх хувь	Тоо	эзлэх хувь	Тоо	эзлэх хувь
А	Нийт	24	868	70994	100.0	154,589.6	100.0	85	100.0	2534	100.0
1	Алтанбулаг		34	1958	2.8	2,704.2	1.7	3	3.5	85	3.4
2	Баянгол		39	2549	3.6	3,378.6	2.2	1	1.2	109	4.3
3	Баруунбүрэн		36	1927	2.7	2,127.4	1.4	0	0.0	134	5.3
4	Бугант		11	987	1.4	1,527.4	1.0	4	4.7	104	4.1
5	Дулаанхаан		11	1559	2.2	1,309.6	0.8	1	1.2	97	3.8
6	Ерөө		38	2799	3.9	2,861.3	1.9	6	7.1	143	5.6

7	Зүүнбүрэн	24	32	1894	2.7	1,909.7	1.2	5	5.9	137	5.4
8	Жавхлант		33	1627	2.3	1,717.2	1.1	1	1.2	114	4.5
9	Мандал		83	8528	12.0	20,871.2	13.5	18	21.2	128	5.1
10	Орхон		32	1669	2.4	1,562.7	1.0	2	2.4	145	5.7
11	Сайхан		53	4071	5.7	6,860.9	4.4	17	20.0	98	3.9
12	Сант		32	2052	2.9	1,618.9	1.0	0	0.0	139	5.5
13	Сүхбаатар		55	5722	8.1	11,393.7	7.4	0	0.0	119	4.7
14	Орхонтуул		39	2468	3.5	2,605.7	1.7	8	9.4	164	6.5
15	Номгон		11	1105	1.6	1,266.8	0.8	4	4.7	93	3.7
16	Түшиг		33	1946	2.7	1,641.4	1.1	3	3.5	85	3.4
17	Цагааннуур		36	2166	3.1	2,698.6	1.7	0	0.0	98	3.9
18	Хушаат		32	1508	2.1	1,572.7	1.0	2	2.4	127	5.0
19	Хүдэр		32	2868	4.0	5,122.2	3.3	0	0.0	124	4.9
20	Шаамар		34	2257	3.2	2,052.6	1.3	1	1.2	110	4.3
21	Хэрх		11	958	1.3	1,604.9	1.0	5	5.9	97	3.8
22	Түнхэл		11	1019	1.4	1,407.9	0.9	4	4.7	84	3.3
23	Аймгийн төрийн сан		140	17357	24.4	74,773.8	48.4	0	0	0	0

Б.1.1.2 Хүснэгтээс үзэхэд нийт гүйлгээний 24.4 хувь, мөнгөн дүнгийн 48.4 хувийг аймгийн төрийн сан гүйцэтгэсэн байна. Тухайн хариуцаж байгаа байгууллагын тоо, санхүүжилтийн хэмжээнээс хамаарч төрийн сангийн нэгжүүдийн жилд хийгдэж байгаа гүйлгээний тоо, зарлагын мөнгөн дүн харилцан адилгүй байна.

Б.1.1.3 Аймаг, сумдын төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, заавар журмын хүрээнд төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийж, төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх, байгууллагын төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн бүртгэлийн дансанд нь санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох, төсвийн орлого, зарлага, хөрөнгө өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Б.1.1.4 Дээрх чиг үүргийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхийг анхан шатны баримт материал руу хөөж, түүвэрлэн үзэхэд дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

Б.1.1.5 Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1², 7.3³, 7.5⁴, 7.13.5⁵ дахь заалтыг зөрчин Хушаат сумын төрийн сангийн нэгж сонгуулийн зардлын дансанд 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгааг маягтын дагуу гаргуулж, нотариатаар батлуулалгүйгээр нийт **5,861.0** мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хийсэн байна.

Б.1.1.6 Сумдын төрийн сангийн нэгжүүд дээрх журмын 7 дугаар зүйлийн 7.5⁶-д заасныг зөрчин баталгаат гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн

² Төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд хяналт тавих, зарлагын гүйлгээ хийх эрхийг хоёр гарын үсгээр баталгаажуулна.

³ Төсвийн байгууллага гарын үсгийн баталгааг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталж, ТТ-3 маягтаар үйлдэн ТЕЗ-даар баталгаажуулж, нотариатаар батлуулан энэхүү журмын 7.2-т заасан зөвшөөрлийн хамт харъяа Төрийн санд хүргүүлнэ.

⁴ Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын 1 болон 2 дугаар гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажсан төлбөрийн хүсэлтийг ...Төрийн санд хүргүүлнэ.

⁵ Энэхүү журмын 7.1, 7.2, 7.3-т заасан бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийхийг хориглоно.

⁶ Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтад заасан ТТ-1, ТТ-2 маягтын дагуу 2 хувь үйлдэн харьяалагдах төрийн санд хүргүүлнэ.

болон бэлэн мөнгөний хүсэлтээр нийт **101,762.6** мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/

Б.1.1.7 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.8⁷ –д заасныг зөрчин анхан шатны баримтын бүрдэл дутуу хяналтын хуудсаар нийт **264,861.3** мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/

Б.1.1.8 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.11.3, 7.11.4-д заагдсан нийт **269,052.4** мянган төгрөгийн орлого бууруулах гүйлгээг хийхдээ журналын ордер, бүртгэлийн дансны орлогыг хуулгыг хавсаргаагүй байгаа нь журмын 7 дугаар зүйлийн 7.12⁸, 8 дугаар зүйлийн 8.6⁹-д заасныг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1 д үзүүлэв/

Б.1.1.9 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.1, 7.13.3¹⁰ –д заасныг зөрчин нийт **486,460.0** мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Үүнд:

- Сайхан сумын төрийн сангийн нэгж 1,420.8 мянган төгрөгийн зардлыг орлого бууруулж гүйлгээ хийсэн,
- Хүдэр сумын төрийн сангийн нэгж худалдан авах ажиллагаа нь хуулийн дагуу зохион байгуулагдаагүй 3 төсөл арга хэмжээний 126,981.3 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээ хийсэн,
- Цагааннуур сумын төрийн сангийн нэгж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулагдаагүй 1 төсөл арга хэмжээний 11,769.9 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээ хийсэн,
- Аймгийн төрийн сан худалдан авах ажиллагаа нь хуулийн дагуу зохион байгуулагдаагүй нийт 9 төсөл арга, хэмжээний 346,288.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг хийсэн,

Б.1.1.10 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.2, 8.10¹¹-д заасныг зөрчин Бугант тосгоны төрийн сан төсвийн байгууллагын нийт 2,225.8 мянган төгрөгийн төлбөр , тооцоог төлбөрийн хүсэлт бичигдсэнээс хойш ажлын 3 өдрөөс илүү хугацааны дараа хянаж, баталгаажуулсан байна.

Б.1.1.11 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.6¹²-д заасныг зөрчин төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ төрийн сангийн тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулалгүйгээр нийт **11,771.6** мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/

Б.1.1.12 Аймаг , сумдын төрийн сангийн нэгжүүд Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.13.2¹³ –д заасныг зөрчин **2,284,686.1** мянган төгрөгийн орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтыг сарын дундуур хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/

⁷ Тухайн байгууллага журмын 7.5-д заасан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: урсгал зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд төсвийн захирагчийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо, ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт, ер төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга, хөрөнгийн зардалтай холбоотой гүйлгээ хийх тохиолдолд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн дансны хуулга болон бусад бичиг баримт хамаарна.

⁸ Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 хоногийн дотор Төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана.

⁹ Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө. Төлбөрийн хүсэлтийн 1 хувь Төрийн санд үлдэнэ.

¹⁰ 7.13. Дараах тохиолдолд зарлагын гүйлгээ гаргахыг хориглоно: 7.13.1. төсвийн тухай хуулийн 24.4, 25.10, 44.3-т заасан; 7.13.3. Төрийн сан энэхүү журмын 7.11, 7.12-т зааснаас бусад тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийх;

¹¹ 8.2. Төрийн сан нь төрийн сангийн төлбөр тоцооны системд бүртгэгдсэн зарлагын гүйлгээг төсвийн байгууллагын төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн баталгаажуулж, ажлын 3 хоногт багтаан эцсийн төлбөр гүйцэтгэх үүргийг хариуцна. Залруулгын нэмэх, хасах гүйлгээг Төв төрийн сан баталгаажуулна. 8.10. Төсвийн байгууллагын ТТ-1, ТТ-2 маягтаар бичигдсэн төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 хоногт хүчинтэй.

¹² Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтэн дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад 1 хувийг өгнө. Төлбөрийн хүсэлтийн 1 хувь Төрийн санд үлдэнэ.

¹³ сар бүрийн эцэст орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтын гүйлгээ тухайн сарын сүүлчийн ажлын өдөр банк хоорондын орлогын гүйлгээ импортлож дууссанаас хойш 1 цагийн дотор сум, дүүрэг, 2 цагийн дотор аймаг, нийслэлийн төрийн сан хийж гүйцэтгэнэ. Орон нутгийн төрийн санд бүртгэлтэй орлогын дансны хаалтыг тухайн орон нутгийн төрийн сан шууд хаана;

Б.1.2 Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлага үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Б.1.2.1 Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвийн 40, ЗГТС-ийн 5, ТЕЗ-ийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 17, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 181 зэрэг нийт 244 төсвийн захирагчийн 868 орлогын болон зарлагын дансанд хяналт тавьж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Б.1.2.2 Аймаг, сумдын төрийн сангийн нэгжийн хариуцаж байгаа төрийн сангийн нэгдсэн дансыг Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т заасан төрлөөр ангилж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №2

№	Дансны зориулалт	Дансны тоо
1	Орон нутгийн ерөнхий болон татварын орлогын	295
2	Урсгал санхүүжилтийн	233
3	Нэмэлт санхүүжилтийн	216
4	Хөрөнгө оруулалт, барьцаа, техник хяналтын	32
5	Хуульд заасан бусад үйл ажиллагааны	92
	Нийт дүн	868

Б.1.2.3 Сумдын төрийн сангийн нэгжүүд нь бүртгэлд байгаа бүртгэлийн дансны бүртгэл хөтөлж, архив үүсгээгүй байгаа нь Төрийн сангийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлийн 5.9-д заасныг зөрчиж байна.

Б.1.2.4 Аудитаар арилжааны банкин дахь төсвийн байгууллагуудын дансдын судалгааг нэгтгэн авч, тулган баталгаажуулалт хийхэд ХААН банканд 89, Төрийн банканд 102, Капитрон банканд 3 зэрэг нийт 194 данс байршиж байна.

Б.1.2.5 Дансдыг зориулалтаар нь ангилж үзэхэд төсвийн орлого төвлөрүүлэх 10, бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх байгууллагын картын 164, халамжийн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх 7, ажилчдын цалин олгох 13 данс байршиж байна.

Б.1.2.6 Аудитаар Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

Б.1.2.7 Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд төсвийн жилийн эхэнд харьяа төсвийн байгууллагуудаас жижиг мөнгөн сангийн хэмжээг тогтоолгох хүсэлтийг хүлээн авч, хязгаарыг тогтоогоогүй нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4¹⁴-д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Б.1.2.8 Төсвийн байгууллагуудын төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайлан, картын дансны хуулгыг хүлээн авч хяналгүйгээр дараагийн жижиг мөнгөн сангийн зузаатгалын нийт **82,993.8** мянган төгрөгийн гүйлгээг хийсэн нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны

¹⁴ Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээг төсвийн жил эхэлмэгц эхний сард багтаан Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтэс, орон нутаг дахь төсвийн байгууллагыг тухайн орон нутгийн төрийн сангийн нэгж баталж эрхийг нээнэ.

журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3, 5.4¹⁵-д заасныг тус тус зөрчсөн байна./*Дэлгэрэнгүйг хавсралт №2- үзүүлэв/*

Б.1.2.9 Сайхан сумын төсвийн байгууллагууд 2017 онд арилжааны банкинд төлбөрийн картан данс нээлгээгүй байснаас шалтгаалж цалингийн түр дансаар 11,824.8 мянган төгрөгийн, Алтанбулаг сумын сургууль нь цалингийн түр дансаар дамжуулж нийт 452.7 мянган төгрөгийн, Зүүнбүрэн сумын ЗДТГ нь нярвын харилцах дансаар 4,311.1 мянган төгрөгийн, Шаамар сумын сургууль, цэцэрлэг 594.6 мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг тус тус хийсэн нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2¹⁶-д заасныг зөрчсөн байна.

Б.1.2.10 Зарим сумдын төрийн сангийн нэгжүүд "Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2, 6.3¹⁷-д заасныг зөрчин төсөвт байгууллагын жижиг мөнгөн сангийн баталсан хязгаараас давсан нийт **166,523.5** мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Баянгол сум 14,491.2 мянган төгрөгийн,
- Ерөө сум 45,707.0 мянган төгрөгийн,
- Сүхбаатар сум 86,884.2 мянган төгрөгийн,
- Түшиг сум 365.0 мянган төгрөгийн,
- Хүдэр сум 19,076.1 мянган төгрөгийн,

Б.1.3 Төсвийн хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулж байна уу?

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийхдээ журмын дагуу хянаж, баталгаажуулаагүй, төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ зардлын эдийн засгийн ангиллын дагуу санхүүжүүлээгүй байна.

Б.1.3.1 Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын дагуу 2017 онд орон нутгийн төсвийн 8 байгууллагын төсвийн зардлын бүлэг хооронд 72,279.9 мянган төгрөгийн, 2 байгууллагын сар, улирлын хуваарьт 22,159.7 мянган төгрөгийн зохицуулалтыг тус тус хийсэн байна.

Б.1.3.2 Төсвийн шууд захирагчаас ирүүлсэн зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх саналыг хүлээн авч гүйцэтгэхдээ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу хянаж, СТСХ-ийн дарга болон төсвийн зарлагын мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Б.1.3.3 2017 оны 11 дүгээр сард боловсрол, соёл урлагийн салбарын төсөвт төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулал, цалин, НДШ, түлш халаалтын зардлын дутуу санхүүжилт, бусад өр төлбөрийг барагдуулах болон Сүхбаатар сумын 4-р цэцэрлэгийн шинээр байгуулагдсан салбарын санхүүжилт, Мандал сумын 4-р сургуулийн дотуур байрны урсгал зардал зэрэг арга хэмжээнд нийт 1,960,600.0 мянган төгрөгийн төсвийн тодотгол хийж, мөн салбарын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн төсөвт 1,220,458.0 мянган төгрөгийн,

¹⁵ 5.3-д " Төсвийн байгууллага нь төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг төлбөрийн картан дансны дэлгэрэнгүй хуулгын хамт хянуулан дараагийн жижиг мөнгөн сангийн эрхээ нээлгэнэ", 5.4-д " Төсвийн байгууллага жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайлан, мэдээг үнэн зөв, тогтоогдсон цаг хугацаанд энэ журмын 5.3, 6.7-д заасны дагуу тайлагнаагүй тохиолдолд төрийн сан тухайн байгууллагын жижиг мөнгөн сангийн зузаатгалыг хойшлуулах эрх эдэлнэ"

¹⁶ Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картан дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар /ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж , урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно.

¹⁷ Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа , ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,0000 төгрөг, тэвэр шатахууны хэмжээ 500,000 төгрөгөөс хэтрэхгүй байна.

- Цэцэрлэгийн төсөвт 655,546.5 мянган төгрөгийн,
- Соёл, урлагийн салбарын төсөвт 84,600.0 мянган төгрөгийн,

Б.1.3.4 Аудитын явцад дээрх төсвийн тодотгол болон төсвийн зохицуулалт хийлгэх саналын материалтай танилцахад “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ТЗБ1 маягтын дагуу зохицуулалт хийх саналыг боловсруулаагүй, төсөвт зохицуулалт хийх шаардлага нарийвчилсан тооцоо тайлбарыг бүрэн бүрдүүлээгүй, СТСХ-т БСУГ-аас ирүүлсэн саналын холбогдох баримт материалыг гарын үсгээр хянаж баталгаажуулж, архивлалгүйгээр төсвийн төлөвлөлтийн программд өөрчлөлт хийж, төсвийн хуваарийг аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Дээрх тодотголын хамт сургууль, цэцэрлэгүүдийн төсөвт зохицуулалтыг хийхдээ 30 сургууль, 2 цэцэрлэгт багаж, техник хэрэгслийн зардалд (5,000.0-40,000.0 мянган төгрөгийн хооронд) нийт 382,500.0 мянган төгрөгийн зардлыг нэмж баталж өгсөн байна.

Б.1.3.5 Эндээс үзэхэд төсвийн зохицуулалт хийх саналын холбогдох баримтууд бүрэн бус, зохицуулалтыг батлагдсан маягтаар хянаж баталгаажуулаагүй, хөрөнгийн шинжтэй багаж, тоног төхөөрөмж худалдан авах зардалд зохицуулалт хийгдсэн зэрэг нь төсвийн зохицуулалтыг журамд заасан шаардлагын дагуу хийгээгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Б.1.3.6 ГХБХБГ-ын барилгын техник хяналтын ажлын 35,175.6 мянган төгрөгийн зардлыг шатахуун, цалин, томилолт гэх мэт зардлын зүйл тус бүрээр бус бөөн дүнгээр нь 210801 буюу бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлын ангилал дээр зарцуулалтын эрхийг тавьж, санхүүжүүлсэн бол аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 614,650.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллаар бус бөөн дүнгээр нь 210901 буюу бараа, ажил, үйлчилгээний бусад зардлын ангилал дээр хянаж, нийт 576,754.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1¹⁸, 5.2¹⁹-д заасныг зөрчиж байна.

Б.1.3.7 Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбарын дагуу дээрх зардлуудын гүйцэтгэлийг тулгахад дараах байдалтай байна.

Хүснэгт №3

№	Зардлын эдийн засгийн ангилал	ГХБХБГ /техник хяналтын зардал/ / мян төг /	БОАЖГ /Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ/ мян төг /
1	Цалин	1,347.9	-
2	Бичиг хэргийн зардал	160.0	264.5
3	Шуудан холбоо	279.2	-
4	Тээвэр шатахууны зардал	21,045.4	10,314.1
5	Ном, хэвлэл худалдан авах	250.0	-
6	Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал	-	18,000.0
7	Дотоод албан томилолтын зардал	8,530.0	15,844.8

¹⁸ Төв төрийн сан улсын төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан зардлын бүлэг болон эдийн засгийн ангиллаар тухайн сарын эхний 5 өдөрт багтаан системд бүртгэж оруулна.

¹⁹ Орон нутгийн төрийн сан нь орон нутгийн төсвийн байгууллага болон Төсвийн тухай хуулийн 15.2-д заасан төсвийн төвлөрүүлэн захирагчдын төсвийн байгууллагуудын зарцуулалтын эрхийг тухайн шатны Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн тухайн сарын ажлын эхний 7 өдөрт багтаан системд бүртгэж оруулна.

8	Урсгал засварын зардал	949.1	-
9	Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардал	660.0	10,961.5
10	Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардал	1,080.0	-
11	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	154.0	223,889.2
12	Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал	720.0	-
13	Бараа, үйлчилгээний бусад зардал	-	92,275.8
14	Хөрөнгө оруулалт: Тоног төхөөрөмж, худалдан авах	-	80,550.2
15	Бусад хөрөнгө оруулалт	-	124,654.2
	Нийт дүн	35,175.6	576,754.3

Б.1.3.8 Эндээс үзэхэд төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зүгээс төсвийн хуваарийг батлахдаа зардлыг хөтөлбөр, зориулалтаар ангилж байгаа боловч зарим зардлын эдийн засгийн ангиллыг төлөвлөсний дагуу зөв хуваарилж батлаагүй байна.

Б.1.3.9 Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-д заасан холбогдох баримтыг бүрдүүлэлгүйгээр зардлын бүлэг хооронд нийт **193,762.3** мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байгаа нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.4²⁰-д заасныг зөрчсөн байна. Үүнд:

Хүснэгт №4

№	Төрийн сангийн нэгжийн нэр	Мөнгөн дүн / мян төг /
1	Алтанбулаг	10,537.5
2	Баянгол	7,033.6
3	Баруунбүрэн сум	1,625.5
4	Ерөө	4491.2
5	Бугант тосгон	870.0
6	Жавхлант	1,420.0
7	Зүүнбүрэн	8,648.9
8	Мандал сум	46,121.1
9	Түнхэл тосгон	870.0
10	Орхон	963.5
11	Орхонтуул	10,720.5
12	Сайхан	13,163.5
13	Сүхбаатар	18,861.3
14	Түшиг	12,778.4
15	Хүдэр	2,647.0
16	Цагааннуур сум	1,673.2
17	Шаамар сум	27,871
18	Дулаанхаан тосгон	3,175.5
19	Аймгийн төрийн сан	20,290.6
	Нийт дүн	193,762.3

Б.1.3.10 Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд харьяа төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны нийт 330,399.7 мянган төгрөгийн зарцуулалтын

²⁰ Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана.

эрхийг нээхдээ төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарийг үндэслэн зардлын эдийн засгийн ангилал бүрээр бус бараа үйлчилгээний бусад зардлын ангилал дээр бөөн дүнгээр тавьж, зардлыг санхүүжүүлж байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1, 7.2.3, 7.3-д²¹ заасныг зөрчиж байна. Үүнд:

- *Аймгийн төрийн сан 6 байгууллагын 321,849.7 мянган төгрөгийн (ХХААГ-ын 117,416.9 мянган төгрөгийн, ЭМГ-ын 56,951.9 мянган төгрөгийн, УЦУОШГ-ын 30,000.0 мянган төгрөг, БСУГ-ын 15,039.6 мянган төгрөгийн, Улсын бүртгэлийн хэлтсийн 60,944.4 мянган төгрөгийн, Статистикийн хэлтсийн 41,496.6 мянган төгрөгийн)*
- *Хушаат сумын төрийн сангийн нэгж сумын ЗДТГ-ын 8,550.0 мянган төгрөгийн,*

Б.1.3.11 Дээрх байдлаас дүгнэхэд Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д заасан “төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх” гэсэн төрийн сангийн нийтлэг чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Б.1.3.12 Шаамар сумын сургууль төсвийн ерөнхийлөн захирагчаас зөвшөөрөл авалгүйгээр 1,140.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансаар зарцуулсан нь Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 1.3²²-д заасныг зөрчсөн байна.

Б.2 ЗГСУМС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?

ЗГСУМС -д сум, тосгоны төрийн сангийн нэгжийг шилэн кабелийн сүлжээгээр холбох ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулж, ЗГСУМС-д түргэн, шуурхай нэвтрэх нөхцөлөөр хангах нь зүйтэй байна.

Б.2.1 Системийг хэрэглэхэд ойлгомжтой, шаардлагатай үйл ажиллагааны хамрах хүрээг хамарч чадсан уу?

ЗГСУМС -д төрийн сангийн нэгжүүд бүрэн холбогдсон боловч 91.3 хувь нь антенаар холбогдож байгаагаас нэвтрэх, гүйлгээ шивэх, хуулга татан авах хурд удаан, сүлжээ тасрах, гацах зэрэг хүндрэлүүд гарч байна.

Б.2.1.1 Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “*бүх шатны төсөв боловсруулах , төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ*” гэж заасны дагуу төрийн сангийн үйл ажиллагааг ЗГСУМС-ээр дамжуулан гүйцэтгэж байна.

Б.2.1.2 2017 оныг дуустал Фрийбаланс программын 6.5 е хувилбарыг , 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Фрийбаланс программын 7.0 хувилбараар ЗГСУМС-д төв, орон нутгийн төрийн сангууд нэвтэрч эхэлсэн байна. Системийн шинэчлэл, аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ, засвар үйлчилгээг төв төрийн сангаас нэгдсэн байдлаар хангаж байна.

²¹ 7.1-д “ Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна”, 7.2.3-д “Нэмэлт төсвийг зарцуулах төсвийн төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарь”, 7.3-д “Төсвийн байгууллагын ирүүлсэн хүсэлтийг журмын 7.2-т заасны дагуу хянан эрхийг ажлын 3 өдөрт багтаан харьяалах төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч, ... олгоно”

²² Нэмэлт орлого олох үйл ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх гэсэн зарчмыг баримтлана.

Б.2.1.3 Төсвийн төлөвлөлтийг Fiscal 5.5 программаар нэгтгэн боловсруулж байсан бол 2018 оноос төсвийн төлөвлөлтийн мэдээллийн систем буюу /BPIS/ программыг нэвтрүүлж эхэлсэн байна.

Б.2.1.4 Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар “ЗГСУМС”-д мөрдөх журмыг баталж, системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчийн ажил үүргийн хуваарь , систем дээр хийгдэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журмын 3-р бүлэгт системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ажил, үүргийн хуваарийг 18 ангилалд хуваасан байна.

Б.2.1.5 ЗГСУМС-д Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын СТСХ болон 17 сум, 5 тосгоны 23 төрийн сангийн нэгжийн нийт 46 хэрэглэгч өөр, өөрийн хариуцсан байгууллага ажил, үүргийн хуваарийн дагуу нэвтэрч байгаа бөгөөд системд бүх төрийн сангийн нэгжүүд бүрэн хамрагдсан байна.

Хүснэгт №5

Ангилал	Албан тушаалын нэр	Хэрэглэгч ийн тоо	Ажил, үүргийн хүрээнд
10	Сумын санхүүгийн албаны дарга буюу ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч-17, Тосгоны төрийн сангийн төлөөлөгч-2	19	<ul style="list-style-type: none"> Гүйлгээ баталгаажуулах Журнал ваучер нэмэх, засах, устгах, харах, хадгалах ТБ1, ТБ1 шилжүүлэг нэмэх, засах, устгах, харах, хадгалах Төсөв, төсөв хоорондын шилжүүлэг нэмэх, засах, устгах, харах, хадгалах ТБ2, Зардлын ваучер болон системээс гарах тайлангууд харах Бэлтгэн нийлүүлэгч нэмэх.
11	Сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн.	22	<ul style="list-style-type: none"> Төсөв, ТБ1, ТБ2 болон системээс гарах тайлангууд харах Зардлын ваучер(гүйлгээ оруулах) нэмэх, засах, устгах, харах, хадгалах.
12	Аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн төсвийн мэргэжилтнүүд	1	<ul style="list-style-type: none"> Журнал ваучер нэмэх, засах, устгах, харах, хадгалах ТБ1, ТБ1 шилжүүлэг нэмэх, засах, устгах, хадгалах Төсөв, төсөв хоорондын шилжүүлэг нэмэх, засах, устгах, хадгалах ТБ2, Зардлын ваучер болон системээс гарах тайлангууд харах.
13	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч	1	<ul style="list-style-type: none"> Журнал ваучер нэмэх, засах, устгах, харах, хадгалах ТБ1, ТБ1 шилжүүлэг нэмэх, засах, устгах, хадгалах Төсөв хоорондын шилжүүлэг нэмэр, засах, устгах, хадгалах ТБ2, Зардлын ваучер болон системээс гарах тайлангууд харах
15	Аймгийн төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд.	2	<ul style="list-style-type: none"> Төсөв, ТБ1, ТБ2 болон системээс гарах тайлангууд харах Зардлын ваучер(гүйлгээ оруулах) нэмэх, засах, устгах, харах, хадгалах.
20	Аймгийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	1	<ul style="list-style-type: none"> Гүйлгээ баталгаажуулах Журнал ваучер нэмэх, засах, устгах, харах, хадгалах Төсөв, ТБ1, ТБ2, Зардлын ваучер болон системээс гарах тайлангууд харах Бэлтгэн нийлүүлэгч нэмэх.

Б.2.1.6 “ЗГСУМС”-д мөрдөх журмын 2.1²³-д заасны дагуу 2017 онд системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн нэрсийн жагсаалтыг гарган аймгийн ЗДТГ-ын 2016 оны 7/295 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.2.1.7 Сэлэнгэ аймгийн хэмжээнд ЗГСУМС-д 2018 оны байдлаар нийт 23 төрийн сангийн нэгж холбогдон ажиллаж байгаагаас аймгийн төрийн сан, Сүхбаатар сумын төрийн сангийн нэгж кабелиар, 21 сум, тосгоны төрийн сангийн нэгж тавган антенаар холбогдож байна.

Б.2.1.8 Антенаар холбогддог төрийн сангийн нэгжийн хувьд шилэн кабелийн холболттой харьцуулахад системд нэвтрэхэд гүйлгээ шивэх, хуулга татан авах хурд удаан, сүлжээ тасрах, гацах зэрэг хүндрэлүүд гардаг байна.

Б.2.1.9 Аудитын явцад ЗГСУМС-ийн 46 хэрэглэгчдээс санал, асуулга авахад дараах байдалтай байна.

Хүснэгт №6

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу?			ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу?			ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?			Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?		
Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй
28	18	0	36	7	3	11	27	8	26	13	7

Б.2.1.10 Санал асуулгын үр дүнг нэгтгэж үзвэл 60,9 хувь нь ЗГСУМС –ийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг, 78,3 хувь нь ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг бүрэн хангадаг, 58,6 хувь нь өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл зарим үед тохиолддог, 56,5 хувь нь хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал хангагдсан гэж хариулсан буюу системийн хэрэглэгчдийн олонх нь эерэг сэтгэгдэлтэй байна.

Б.2.1.11 Санал асуулгад хамрагдсан хүмүүсийн 58,6 хувь нь системд өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл зарим үед тохиолддог гэж хариулсан нь 21 сум, тосгоны төрийн сангийн нэгж ЗГСУМС-д тавган антенаар холбогдож байгаатай холбоотой гэж үзэж байна.

Б.2.2 Системийн программ хангамж, мэдээллийн технологи аюулгүй ажил хангагдсан уу?

ЗГСУМС-ийн программ хангамж, мэдээллийн аюулгүй ажиллагаанд төв төрийн сангаас хяналт тавьж ажиллаж байна.

Б.2.2.1 ЗГСУМС-ийн журмын 3 дугаар зүйлд заасан ангиллын дагуу Сэлэнгэ аймгийн төрийн сан болон сум тосгоны төрийн сангийн нэгжийн хэрэглэгч бүр өөр өөрсдийн нэвтрэх нэр, нууц үгээр ЗГСУМС-д нэвтэрч байна.

²³ Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс, аймаг, нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсүүд харьяа аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн нэгжүүдийг нэгтгэн шинэ оны системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн нэрсийн жагсаалтыг энэхүү журмын 3 дугаар бүлгийн ажил үүргийн ангиллын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Төв төрийн санд албан бичгээр ирүүлнэ

Б.2.2.2 Системийн аюулгүй ажиллагааны талаар журамд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- *Журмын 3 дугаар зүйлийн 3.1-д “3”– системийн ажил үүргийн энэ ангилалд Системийн функциональ администратор. ЗГСУМС-ийн хэвийн үйл ажиллагааг ханган, холбогдон ажиллаж буй хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, систем дээр шинээр данс нээх болон бэлтгэн нийлүүлэгч оруулах, системийн хэрэглэгчийн бүртгэл хийх болон эрх тогтоох, системийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.*
- *Журмын 5 дугаар зүйлийн 5.1-д “ Системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтан хэрэглэгчийн нэр, нууц үгийг энэ журмын 2.4, 2.5 дахь заалтыг зөрчсөнөөс үүсэж болох эрсдэлийг тухайн төрийн сан, системийн хэрэглэгч өөрөө хариуцна.*

Б.2.2.3 ЗГСУМС-ийн засвар, үйлчилгээ, аюулгүй ажиллагааг төв төрийн сангаас нэгдсэн журмаар хэрэгжүүлж байгаа бөгөөд, аймаг, сумдын төрийн сангийн нэгжид хариуцсан орон тооны ажилтан байхгүй байна.

Б.2.2.4 Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь ЗГСУМС-д мөрдөх журмын 5.3²⁴-д заасны дагуу улирал бүр хэрэглэгчийн эрхийг түр шилжүүлсэн болон өөрчлөгдсөн талаарх тайланг хүргүүлж байна.

Б.2.2.5 Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан /ЗГСУМС-д/ мөрдөх журмын 2.4 “ Системд нэвтрэх эрх бүхий аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн мэргэжилтнүүд ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, амралтаа авсан, зайлшгүй шаардлагаар, өөрийн эрх, нууц үгээ шилжүүлэх тохиолдолд энэ тухай албан бичгийг төв төрийн санд зайлшгүй ирүүлнэ” гэж заасан боловч сумдын төрийн сангийн төлөөлөгчид ээлжийн амралт авсан үед эрх, нууц үгээ шилжүүлээгүй байна.

Б.2.2.6 Аудитын явцад сумдын Санхүүгийн албаны дарга нартай ярилцлага хийж, асуулга авахад санхүүжилтээс шалтгаалан төсөвт байгууллагуудын зарлагын гүйлгээнүүд сарын сүүлээр хийгддэг тул ээлжийн амралтыг ихэвчлэн сарын дундуур авах, шаардлагатай тохиолдолд амралтын дундуур ирж ажил, үүргээ гүйцэтгэх байдлаар зохицуулдаг учир ээлжийн амралт авсан үед эрх, нууц үгээ шилжүүлдэггүй, өөрөөр хэлбэл шаардлагагүй гэж үздэг байна.

Б.2.2.7 2017 онд сумын төрийн сангийн нэгжүүдээс журмын 2 дугаар зүйлийн 2.6²⁵-д заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх хүсэлтийг аймгийн төрийн санд ирүүлснийг хянаж үзэн, аймгийн төрийн сангаас хэрэглэгчийг хязгаарлах, шинээр бүртгүүлэх хүсэлтийг системийн функциональ администраторт нийт 19 удаа хүргүүлж, хэрэглэгчийг өөрчлүүлж, хэрэглэгчийн эрхийг түр хугацаагаар нийт 28 удаа шилжүүлсэн байна.

Б.2.2.8 Журмын 5 дугаар зүйлийн 5.9-д “*Журмын зүйлд заасан эрхүүдийг нэг албан тушаалтанд давхардуулан олгохгүй бөгөөд өөрт оногдсон эрхээс өөр эрхээр системд нэвтэрч ажил, үүрэг гүйцэтгэхийг хориглоно. Журмын энэхүү заалт нь сумын санхүүгийн албаны албан тушаалтанд хамаарахгүй*” гэж заасан нь сумын төрийн сангийн нэгжийн хувьд орон тооны нөхцөл байдлаас шалтгаалж байгаа хэдий ч төрийн сангийн анхан шатны нэгжийн тухайн цаг хугацааны төлбөр, тооцооны хяналт сулрах эрсдэлийг үүсгэж байна.

Б.2.2.9 Аудитын явцад ЗГСУМС-ийн хэрэглэгчдээс системийн аюулгүй ажиллагаа хангагдаж байгаа эсэх талаар санал, асуулга авахад дараах байдалтай байна.

²⁴ Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь ЗГСУМС-ийн хэрэглэгчийн ажил, үүргийн ангилал, хуваарь, нэгдсэн жагсаалтыг улирал тутам хянаж, хэрэглэгчийн эрхийг түр хугацаанд шилжүүлсэн болон өөрчлөлтийн тайланг, газар хэлтсийн дарга нараар хянуулан, Төв төрийн санд дараа сарын 15-ны дотор хүргүүлнэ.

²⁵ Тухайн төсвийн жилийн системийн хэрэглэгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх тухай албан хүсэлтийг Төв төрийн санд аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэс, сум дүүргийн хэрэглэгчийн хувьд харьяа аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсээр дамжуулан, Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс холбогдох тушаал, шийдвэрийн хуулбарын хамт ирүүлнэ.

Системийн функциональ администратор журамд заасан хугацаанд тайлант үеийг өндөрлүүлж, эхлүүлж байна уу?			Танд зохих эрхийг бүрэн олгосон уу?			Системд нэвтрэх нэр, нууц үгийг журмын дагуу олгосон уу?			Таны эрхийг хязгаарласан тохиолдол бий юу?			Системийн функциональ администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг журмын дагуу гүйцэтгэж байна уу?			Таны эрхийг давхардуулан ашигладаг хэрэглэгч байгаа юу?		
Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй	Тийм	Зарим талаар	Үгүй
43	1	2	40	6	0	41	3	1	2	2	42	38	5	3	0	0	46

Б.2.2.10 Санал асуулгын дүнг нэгтгэн авч үзвэл асуулт тус бүрд 82,6-100,0 хувь эерэг хариулт буюу системийн аюулгүй ажиллагаа хэвийн хангагдсан гэсэн хариултыг өгсөн байна.

Б.2.2.11 Сангийн сайдын 2014 оны оны 95 дугаар тушаалаар баталсан “ЗГСУМС-д мөрдөх журам”-д системийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажиллах талаар болон , алдаа, зөрчил гаргасан ажилтнуудад авах хариуцлагын арга хэмжээний талаар тодорхой тусгагдаагүй байна.

Б.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Сум, тосгоны төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Б.3.1 Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Зарлагын гүйлгээний мөнгөн дүнгийн 48 хувийг эзэлж байгаа аймгийн төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Б.3.1.1 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Б.3.1.2 Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн үйл ажиллагаанд Төв төрийн сангаас дотоод хяналт, шалгалт 2014 оноос хойш хийгдээгүй байна.

Б.3.1.3 Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь “Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх журам”-ын дагуу төрийн сангийн нэгжүүдийн өдөр тутмын болон системийн хяналтыг хэрэгжүүлж, сумд, төсөвт байгууллагуудын ТБ1, ТБ2 –ийн зөрүү, орлогын дансдын үлдэгдэл,

ОНЕОрлогын дансны улайлт, буруу шивсэн гүйлгээ зэргийг засуулж, системд үүссэн зөрүүг цаг тухайд нь арилгуулж ажилласан байна.

Б.3.1.4 Аймгийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь журмын 5.1, 5.3-д заасны дагуу төрийн сангийн нэгжүүдээр эрсдэлийн үнэлгээ хийн нэгтгэж, эрсдэлийн үнэлгээ нь 21-40 буюу дунд эрсдэлтэй 10 төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийхээр төлөвлөн, аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Б.3.1.5 Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Зүүнбүрэн, Сант, Түшиг, Хушаат, Шаамар сумд, Дулаанхаан, Номгон тосгон зэрэг 8 сум, 2 тосгоны төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, Сүхбаатар сум, Бугант тосгоны төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хийсэн байна.

Б.3.1.6 Дотоод хяналтын журмын 7.1-д заасны дагуу санхүүжилт болон тайлагналын хяналтын, төлбөр тооцооны, системийн хяналтын, төрийн сангийн дотоод үйл ажиллагааны гэсэн 4 үндсэн чиглэлээр хяналт гүйцэтгэсэн байна. Дотоод хяналт шалгалтаар дараах алдаа, зөрчил нийтлэг байдлаар илэрсэн байна. Үүнд:

- *Түшиг, Хушаат, Зүүнбүрэн, Шаамар сумдын төрийн сангийн нэгжийн орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийг олгосон ЗЭБ№1 маягтаарх дүн болон ЗГСУМС дээр олгосон санхүүжилтийн дүн нь хоорондоо зөрүүтэй.*
- *Сант, Зүүнбүрэн, Бугант тосгоны төрийн сангийн нэгж төсөвт байгууллагуудаас авсан сарын мэдээгээр хүлээн авсан өр төлбөрийн дүн нь ЗГСУМС-ийн дүнгээс зөрүүтэй,*
- *Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг хянахдаа журмын 7.1-7.5-д заасныг баримтлаагүй зөрчил нийтлэг байдлаар,*
- *Бугант тосгоны төрийн сангийн нэгж гарын үсгийн баталгааг шинэчлээгүй, Баянгол сумын төрийн сангийн нэгж гарын үсгийн баталгааг нотариатаар баталгаажуулаагүй,*
- *Төрийн сангийн нэгжүүд зарлагын гүйлгээг хянан гүйцэтгэхдээ засвартай болон 1,2-р гарын үсэг дутуу төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн зөрчил нийтлэг байдлаар,*
- *Орлого бууруулсан гүйлгээнд мемориалын ордер, бүртгэлийн дансны орлогын хуулга хавсаргаагүй,*
- *Хушаат, Баянгол, Номгон тосгоны төрийн сангийн нэгж төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийг хэвлэж мемориалын баримтад хавсаргаагүй, нэгдсэн товъёог баталгааны хуудас хийгээгүй,*
- *Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журамд заасан 300.0 мянган төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг хянахдаа төсвийн байгууллагаас албан хүсэлтийг нь хүлээн авч хянаагүй,*

Б.3.1.7 Тухайн жилийн дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулахдаа журмын дагуу эрсдэлийн үнэлгээг харгалзан төрийн сангийн нэгжийг сонгож байгаа боловч нийт гүйлгээний тооны 24.4 хувь, зарлагын гүйлгээний мөнгөн дүнгийн 48 хувийг эзэлж байгаа аймгийн төрийн санд 2014 оноос хойш дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.3.1.8 Сумдын Санхүүгийн албадууд оны эхэнд дотоод хяналтын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

Б.3.1.9 Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 8 дугаар зүйлийн 8.1²⁶-д заасны дагуу 2017 оны дотоод хяналтын нэгдсэн тайланг Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.

²⁶ Аймаг, нийслэлийн төрийн сан нь журмын 4.3-т заасан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайланг тухайн шатны засаг даргад танилцуулсны үндсэн дээр Сангийн яамны Төрийн сангийн газарт, дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор цахим болон албан бичгээр ирүүлнэ.

Б.3.2 Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагын чиглэлээр өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна.

Б.3.2.1 2017 онд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 23 төрийн сангийн нэгжийн 52.2 хувийнх нь төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хийж, илэрсэн алдаа, зөрчилтэй холбогдуулан давхардсан тоогоор 142 зөвлөмж өгсөн байна.

Б.3.2.2 Оны эцэст дотоод, хяналт шалгалт хийгдсэн төрийн сангийн нэгж бүрээс зөвлөмжийн хэрэгжилтийн талаар товч тайлан гаргуулан биелэлтийг 97.9 хувьтай гэж дүгнэсэн байна.

Б.3.2.3 Гэвч бидний хийсэн аудитаар төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагатай холбоотой дараах алдаа, зөрчил давтагдан гарч байгаагаас үзэхэд зөвлөмжийн хэрэгжилт бодитой бус гэж дүгнэхэд хүргэж байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 болон Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13.1-д заасныг зөрчин худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулагдаагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн,*
- *Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг зөрчин төсвийн захирагчаас төсөвт зохицуулалт хийхийг хүссэн саналын материал ирүүлээгүй байхад зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан төлбөр тооцоог хянаж, гүйцэтгэсэн,*
- *Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг бүрэн мөрдөөгүйгээс төсвийн захирагч нараас ирүүлсэн төсөвт зохицуулалт хийх саналын холбогдох баримтууд бүрэн бус, зохицуулалтыг батлагдсан маягаар хянаж баталгаажуулаагүй, хөрөнгийн шинжтэй багаж, тоног төхөөрөмж худалдан авах зардалд зохицуулалтыг хийсэн,*
- *Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ыг зөрчин харьяа төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ төсвийн захирагчийн баталсан сар, улирлын хуваарийг үндэслэн зардлын эдийн засгийн ангилал бүрээр бус бараа үйлчилгээний бусад зардлын ангилал дээр бөөн дүнгээр тавьж, зардлыг санхүүжүүлсэн,*
- *Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчин:*
 - *Төсвийн жилийн эхэнд харьяа төсвийн байгууллагуудаас жижиг мөнгөн сангийн хэмжээг тогтоолгох хүсэлтийг хүлээн авч хязгаарыг тогтоогоогүй,*
 - *Төсвийн байгууллагуудын төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайлан, картын дансны хуулгыг хүлээн авч хяналгүйгээр дараагийн жижиг мөнгөн сангийн зузаатгалын гүйлгээг хийсэн,*
 - *Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хязгаарсан давсан бэлэн мөнгөний гүйлгээг хийхдээ тухайн байгууллагаас албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв зэргийг хянан үзээгүй.*

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **4,738,637.5** мянган төгрөгийн зөрчил / **Дэлгэрэнгүйг Хавсралт 1-3 т үзүүлэв** / илэрснээс **464,662.5** мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, **4,273,975.0** мянган төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөв. Үүнд:

Албан шаардлага:

- 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгааг журмын дагуу үйлдүүлэн нотариатаар батлуулалгүйгээр төрийн сангийн бүртгэлийн данснаас гүйлгээ хийсэн **5,861.0** мянган төгрөгийн,
- Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.1-д заасныг зөрчин худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулагдаагүй төсөл, хөрөнгө арга хэмжээг санхүүжүүлсэн **265,039.2** мянган төгрөгийн,
- Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-д заасан холбогдох баримтыг бүрдүүлж, төсөвт зохицуулалт хийх санал ирүүлээгүй байхад төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.4²⁷-д заасныг зөрчин зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан **193,762.3** мянган төгрөгийн зэрэг нийт **464,662.5** мянган төгрөгийн зөрчилд тус тус зөрчил арилгуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Зөвлөмж:

- Төрийн сангийн үйл ажиллагааны журмын бусад заалтуудыг зөрчсөн нийт **3,155,780.6** мянган төгрөгийн,
- Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмыг зөрчсөн **850,053.9** мянган төгрөгийн,
- Төсөвт байгууллагын кассын үйл ажиллагааны болон бусад холбогдох журмыг зөрчсөн **268,140.5** мянган төгрөгийн зэрэг нийт **4,273,975.0** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөв.

²⁷ Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, сумдын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын бүтэц, орон тоонд багтан үйл ажиллагаа явуулж байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх байдал алдагдах эрсдэлийг үүсгэж байна.
- Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актууд бусад хууль, тогтоомжуудтай зөрчилдөхгүй байна.
- Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа зарим хууль, журам, зааварт шинэчлэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, төлөвлөх, тайлагнах чиг үүргийг төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжүүлэх чиг үүрэгтэй хамтатган гүйцэтгэж байна.
- Сумдын Санхүүгийн алба нь хариуцаж байгаа байгууллагын тоо, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтаас шалтгаалан бүтцийн хувьд харилцан адилгүй зохион байгуулагдсан байна.
- Сумдын Санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг нэн даруй өөрчлөн, нягтлан бодогчийн ажлын ачаалал, цалин хөлсний ялгавартай байдлыг арилгах шаардлагатай байна.
- Төрийн сангийн нэгжүүд нь төсвийн байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.
- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын хэрэгжилтэд тавих хяналт сул байна.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт хийх зохицуулалтыг журмын дагуу хянаж, баталгаажуулаагүй, төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ зардлын эдийн засгийн ангиллын дагуу санхүүжүүлээгүй байна.
- ЗГСУМС -д төрийн сангийн нэгжүүд бүрэн холбогдсон боловч 91.3 хувь нь антенаар холбогдож байгаагаас нэвтрэх, гүйлгээ шивэх, хуулга татан авах хурд удаан, сүлжээ тасрах, гацах зэрэг хүндрэлүүд гарч байна.
- ЗГСУМС-ийн программ хангамж, мэдээллийн аюулгүй ажиллагаанд төв төрийн сангаас хяналт тавьж байна.
- Сум, тосгоны төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.
- Төрийн сангийн дотоод хяналт шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчил давтагдан гарсаар байна

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

- Сумдын Санхүүгийн албаны бүтэц, орон тоонд дүн шинжилгээ хийж, оновчтой байдлаар зохион байгуулах, нягтлан бодогчдын ажлын ачаалал, цалин хөлсийг тэнцвэржүүлэх.
- Орон нутгийн төсөвт байгууллагуудын төсвийн хуваарийг төлөвлөсөн зардлын эдийн засгийн ангиллын дагуу хийж, батлуулах.


Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга М.Нарантуяа-д:

- 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн баталгааг журмын дагуу үйлдүүлэн нотариатаар батлуулсны үндсэн дээр гүйлгээ хийх.
- Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.1, 7.13.3 –д заасныг зөрчин орлого бууруулж болон худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулагдаагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.
- Төлбөр тооцоог Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу хянаж, гүйцэтгэж байх.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 4.2-д заагдсан саналын материалын дагуу хүлээн авч, хянаж баталгаажуулж байх.
- Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ын 7.2, 7.3-д заасны дагуу хүлээн авч төлөвлөсөн зардлын эдийн засгийн ангиллаар хянаж, зардлыг санхүүжүүлж байх.
- Төрийн сангийн нэгжийн эрсдэлийн үнэлгээг үнэн зөв тодорхойлж, дотоод хяналтыг үр дүн нөлөөтэй хэрэгжүүлэх.

Сумдын Санхүүгийн албаны дарга нарт:


- Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлж, төлбөр тооцоог гүйцэтгэх, дотоод хяналт шалгалтаар болон аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.
- "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын холбогдох заалтыг бүрэн гүйцэт хэрэгжүүлж ажиллах;
- Санхүүгийн албаны дотоод хяналтыг оновчтой төлөвлөж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМОНХ
С.БАТ-ЭРДЭНЭ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР**



Тайлбар хүргүүлэх тухай

Тайлбар 1-ийг үзнэ

-Засаг даргын нөөц хөрөнгө нь нэг зардлын зүйлээр төлөвлөгдөж батлагддаг. Зардлыг зардлын зүйлээр задлах боломжгүй.

-Сангийн яаманд төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд нэг зардлын ангилалаар тайлагнадаг. Зардлын зүйлээр задлавал нэгтгэлийн тайлан гарахад маш төвөгтэй байдал үүсэж бүртгэлийн устгал хийх боломжгүй байдалд хүрдэг.

Тайлбар 2-ыг үзнэ

-ЗДТГ-аас бүх мэргэжилтнүүд нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд хамруулан Тагнуулын газарт хүргүүлсэн. Байгууллагад нууцын ажилтан хуулийн дагуу нэг хүн ажилладаг учраас Төрийн санд тусгай нууцын ажилтан байх шаардлагагүй гэсэн тайлбарыг Тагнуулын газраас ирүүлсэн.

Тайлбар 3-ыг үзнэ

-Нууц захирамж гарсан тохиолдолд тухай бүр нууцын баталгааг ЗДТГ-ын бичиг хэргийн эрхлэгч гаргуулан авдаг.

-Монгол Улсын Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/1085 тоот тушаалаар батлагдсан Улс, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр баригдах барилга байгууламжийн болон барилга захиалагчийн хяналтын зардлыг Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1-дэх заалт, Засгийн газрын 2009 оны 73-р тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга захиалагчийн дүрэм", Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторын хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр"-ийг заасан чиг үүрэгт хамаарагдан үйл ажиллагаанд зарцуулна гэсний дагуу барилгын техник хяналт гэсэн зориулалтаар батлагдсан төсвийн хүрээнд төрийн сан гүйлгээ хийсэн.

Тайлбар 4-ийг үзнэ

-Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.13.2-т заасан " сар бүрийн эцэст орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтын гүйлгээг тухайн сарын сүүлчийн өдөр банк хоорондын орлогын гүйлгээ импортлож дууссанаас хойш 1 цагийн дотор сум, дүүрэг, 2 цагийн дотор аймаг, нийслэлийн төрийн сан хийж гүйцэтгэнэ" гэсэн заалт нь сарын бүх орлогыг зөвхөн сарын эцэст хаана гэсэн утга агуулга биш юм. Харин сарын сүүлд орлогын дансууд тэг үлдэгдэлтэй бөйх ёстой учраас сарын эцэст үлдэгдэл орлогыг хаах тухай ойлголт юм.

-Ийм учраас энэ заалтаар илрүүлсэн зөрчлийг дахин хянаж, зөрчлийн дүнгээс хасуулах саналтай байна. Аймаг сумын орон нутгийн төвийн орлогын гүйцэтгэлээс хамгааран орон нутгийн төсөвт байгууллагууд болон хөрөнгө оруулалт, шууд зардлын санхүүжилт олгогддог учраас зөвхөн сарын эцэст орлогыг хаах боломжгүй юм.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

- **Тайлбар 1:**

Тайлангийн төслийн Б.1.3.10 -д “Аймаг, сумдын төрийн сангийн нэгжүүд харьяа төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарийг үндэслэн зардлын эдийн засгийн ангилал бүрээр бус бараа үйлчилгээний бусад зардлын ангилал дээр бөөн дүнгээр тавьж, зардлыг санхүүжүүлж байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна”, 7.2 –т “Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээлгэх хүсэлтийг НТН№1 маягтын дагуу бэлтгэн дараах материалын хамт төв болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд ирүүлнэ”....., 7.2.3-т “Нэмэлт төсвийг зарцуулах төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарь”, 7.3 –т “Төсвийн байгууллагын ирүүлсэн хүсэлтийг журмын 7.2 –т заасны дагуу хянан эрхийг ажлын 3 өдөрт багтаан харьяалах төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч, төв төрийн сангийн тухайд хариуцсан мэргэжилтэн олгоно” гэж заасныг зөрчиж байна” гэж дурдсан юм.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3-д “Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн төсөвт нийт дүнгээр тусган тухайн шатны ИТХ-аар батлуулна” гэж заасны дагуу бөөн дүнгээр төлөвлөж, зарцуулагдаж байна.

Харин Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжилт авсан байгууллагын хувьд зардлын эдийн ангиллаар зарцуулж, тайлагнах үүрэгтэй бөгөөд харьяа төрийн сангийн хувьд ч мөн адил Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д заасан “төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх” гэсэн төрийн сангийн нийтлэг чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл болох тул дээрх тайлбарыг хүлээн авах боломжгүй юм.

- **Тайлбар 2:**

Тайлангийн төслийн Б.1.2.6 –д “Сэлэнгэ аймгийн төрийн сан нь Хилийн цэргийн 0101, 0243 дугаар анги, Тагнуулын газар зэрэг 3 нууцын зэрэглэлтэй байгууллагын төлбөр тооцоог хянаж, баталгаажуулдаг. Гэвч нууц хариуцсан мэргэжилтэн томилж, нууцын баталгаа гаргуулаагүй бөгөөд нууцад хамаарах мэдээллийг ялгах, нууцлах, хадгалах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар ямар нэгэн шийдвэр байхгүй байна”., Б.1.2.7-д “Иймд нууцад хамаарах мэдээлэлтэй ажиллаж байгаа мэргэжилтнүүдээр нууцын баталгаа гаргуулж, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна” гэсэн хэсэгт ирүүлсэн тайлбарыг хүлээн авч дээрх хэсгийг тайлангаас хасав.

- **Тайлбар 3:**

Тайлангийн төслийн Б.1.3.6-д “ГХБХБГ-ын барилгын техник хяналтын ажлын 35,175.6 мянган төгрөгийн зардлыг шатахуун, цалин, томилолт гэх мэт зардлын зүйл тус бүрээр бус бөөн дүнгээр нь 210801 буюу бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлын ангилал дээр зарцуулалтын эрхийг тавьж, санхүүжүүлсэн байна” Энэ нь Сангийн сайдын 2014 оны 7 дугаар тушаалаар баталсан “зардлын

эдийн засгийн ангилал”, 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “зардлын эдийн засгийн ангиллын тайлбар” болон Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 –д “Төв төрийн сан улсын төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан зардлын бүлэг болон эдийн засгийн ангиллаар тухайн сарын эхний 5 өдөрт багтаан системд бүртгэж оруулна”, 5.2²⁸-д “Орон нутгийн төрийн сан нь орон нутгийн төсвийн байгууллага болон Төсвийн тухай хуулийн 15.2-д заасан төсвийн төвлөрүүлэн захирагчдын төсвийн байгууллагуудын зарцуулалтын эрхийг тухайн шатны Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн тухайн сарын ажлын эхний 7 өдөрт багтаан системд бүртгэж оруулна” заасантай тус тус зөрчилдөж байна” гэж дурдагдсан юм. Зардлыг эдийн засгийн ангиллаар бус бөөн дүнгээр зарцуулалтын эрхийг олгож байгаа нь төсвийн хэрэгжилтэд зардлын бүлэглэсэн дүнгээр хяналт тавих зарчмыг алдагдуулж байгаа учир 2019 оны төсвийн хуваарийг батлахдаа зардлыг бөөн дүнгээр бус эдийн засгийн ангилал бүрээр задалж, зарцуулалтын эрхийг олгож байх нь зүйтэй байна.

Иймд тайлбарыг хүлээн авах боломжгүй юм.

- **Тайлбар 4**

Төсвийн орлогын дансны хаалтыг хэрхэн гүйцэтгэх талаар Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 13.1, 13.2-д “ улс, орон нутгийн төсвийн орлогын дансны хаалтын гүйлгээг тухайн сарын сүүлчийн ажлын өдөр банк хоорондын орлогын гүйлгээ импортлож дууссанаас хойш 1 цагийн дотор сум, дүүрэг, 2 цагийн дотор аймаг, нийслэлийн төрийн сан хийж гүйцэтгэнэ” гэж буюу сар бүрийн сүүлчийн ажлын өдөр хийж гүйцэтгэхээр тодорхой заасан учир уг саналыг хүлээн авах, зөрчлийн дүнгээс хасах боломжгүй байна. Харин төсвийн зардлын санхүүжилтийг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 3.2 –д заасан дарааллыг баримтлан гүйцэтгэх боломжтой юм.

Төсвийн орлогын хаалтыг сарын эцэст хийж байгаа нь орон нутгийн түвшинд хүндрэлтэй байгаа талаар ирүүлсэн тайлбарыг аудитын тайлангийн А.2.1.6 –д буюу “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага байна уу” гэсэн хэсэгт нэмж оруулав.